

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 5 ДУГААР  
САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хот суурин, дэд бүтцийн хөгжлийн хороо 2022 оны 5 дугаар сарын 17-ны өдөр хуралдаж жилийн ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, цаашид хийж хэрэгжүүлэх ажил арга хэмжээний талаар санал солилцож төлөвлөгөөгөө баталсан.

Мөн Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооны хуралдаж “Өрх бүр үйлдвэрлэгч”, “Монгол малчин” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцаж, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлээ.

2022 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хорооны хурлыг зохион байгуулж, дараах гурван асуудлыг хэлэлцсэн байна. Үүнд:

Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлж, хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөв, дадал хэвшилтэй болгох үйл ажиллагааг идэвхжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих;

“Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлж, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулан, төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс гаргуулдаг байдлыг халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авах боломжийг бүрдүүлэх чиглэлд анхаарах;

“Цахим эрүүл мэнд” арга хэмжээ хэрэгжүүлж, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэн, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоонд шилжих үйл явцтай танилцах ажлыг зохион байгууллаа.

Хуралдаанаас гарсан санал, дүгнэлтийг аймгийн Засаг дарга, Сумдын засаг даргад нарт хүргүүлсэн байна.

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл**

2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр аймгийн удирдах ажилтны зөвлөгөөнийг аймгийн Засаг даргын тамгын газрын Хурлын танхимд зохион байгуулж 4 дүгээр сард өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг танилцуулж, Улсын Бүртгэлийн хэлтэс, Архангай аймаг дахь Монгол банкны салбарын мэдээлэл хийлээ.

Мөн энэ өдөр аймгийн Засаг дарга М.Батжаргал байгууллагын дарга нарт холбогдох үүрэг даалгавар болон анхаарах ажлын чиглэлийг өгсөн.

Статистикийн тухай хуулийн дагуу 10 жилд нэг удаа зохион байгуулдаг хөдөө аж ахуйн салбарын тооллогыг Архангай аймагт 2022 оны 6 сарын 4-ний өдрөөс 6 сарын 17-ны өдөр хүртэл зохион байгуулахаар тоологч, шалгагчийн хоёр өдрийн сургалтыг 5 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд зохион байгуулж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

5 дугаар сарын 20-ны өдөр Бүгд найрамдах Польш улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Кшыштоф Збигнев бойко Архангай аймагт албан айлчлал хийлээ.

Элчин сайд Збигнев Бойкогийн албан айлчлалын үеэр аймгийн удирдлагуудтай уулзалт хийж, уулзалтын хүрээнд Польш улс Монгол улстай гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагаагаа тэлж байгаа, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын бүс нутаг болсон Архангай аймагтай хамтран ажиллах боломжуудын талаар талууд санал бодлоо солилцсон байна.

Архангай аймгийн ЗДТГ-аас тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран 5 дугаар сарын 20-ны өдөр Нээлттэй хаалганы өдөрлөг, Нэгдсэн тоо арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Нэгдсэн тоонд аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээ алба зэрэг байгууллагуудын нийт 120 гаруй албан хаагч оролцож иргэд олон нийтэд үйл ажиллагаагаа таниулан сурталчилсан байна.

Нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр урлагийн тогтлолт болон оройн тоо, жагсаалын арга хэмжээг олон нийтэд толилуулсан.

Архангай аймгийн утга зохиолын “Хантамир” төв санаачлан аймгийн 100 жилийн ойд зориулан бүтээсэн “ХАНТАМИРЫН АЙ” номын нээлтийг 5 дугаар сарын 21-ны өдөр Эрдэнэбулган суманд зохион байгууллаа.

Номын нээлтэд аймгийн Засаг дарга М.Батжаргал, ЗДТГ-ын дарга Ц.Бадрах, Хантамир төвийн зохиолч, яруу найрагчид, аймгийн Нийтийн номын сан, ном, судраа эрхэмлэн дээдлэгч иргэдийн төлөөлөл, хүүхэд багачууд оролцлоо.

Хантамирын ай ном нь Архангай нутгаас гарвалт сүүлийн 400 орчим жилд төрсөн 370 гаруй зохиолчийн бүтээл болоод аймгийн урчуудын эвлэлийн гишүүдийн бүтээлийг багтааснаараа онцлог юм.

2022 оны 5 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд Архангай аймагт “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд” арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд албан байгууллага, аж ахуйн нэгж СӨБ, ЕБС-иудын бага, дунд, ахлах насны ангиллаар нийт 5 уралдааныг зохион байгуулж, шилдгүүдийг шалгарууллаа. Түүнчлэн “Архангайн зохиолчдын “Хан Тамирын ай” шинэ номын нээлт, МУ-ын СГЗ, зохиолч, сэтгүүлч Г. Жамцын “Бүтээлийн чуулган 8 боть” шинэ номын нээлтийг тус бүр зохион байгууллаа. 4 өдрийн арга хэмжээнд нийт 1500 гаруй хүн хамрагдлаа.

Архангай аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг спортын “Дөл-2022” цогцолбор тэмцээнийг 5 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулж, тэмцээнд аймгийн төвийн болон сумдын ЕБС-ийн ахлах ангийн сурагчдаас бүрдсэн 11 багийн 143 тамирчин сурагч оролцсоноос “Дөл-2022” цогцолбор 5 төрлийн тэмцээний нийлбэр дүнгээр Эрдэнэбулган сумын 5-р сургуулийн баг, тамирчид түрүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Цахим Архангай” төрийн шуурхай үйлчилгээг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу “Цахим аймаг” хөтөлбөрийн төслийг боловсруулж Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн, 2022 оны 6 дугаар сард гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж Эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээний цахим шийдэл, Сургуулийн сургалтын удирдлагын цахим шийдэл, Хөрөнгө оруулалтын удирдлагын цахим шийдэл, Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын цахим шийдэл, Аймгийн орон зайн мэдээллийн систем, Тээврийн хэрэгслийн хяналтын цахим шийдэл, Автомат шалган нэвтрүүлэх шийдэл, Аймгийн иргэдэд зориулсан нэгдсэн гар утасны аппликейшн зэрэг системүүдийг үе шаттайгаар нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам, e-mongolia академтай хамтран Архангай аймгийн иргэдэд Бүх нийтэд мэдээллийн технологийн ур чадварыг олгох 2 өдрийн сургалтыг 5 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд зохион байгуулж, сургалтад танхимаар 140 иргэн, 67 төрийн албан хаагч, цахимаар 100 иргэн, нийт 307 иргэн хамрагдсан байна.

Мөн орон нутгаас олгож байгаа тусгай зөвшөөрөл, архивын лавлагаа зэрэг төрийн үйлчилгээг И Монголиа нэгдсэн системд холбож хариуцсан мэргэжилтнүүд, сумдын оператор ажилтнуудын тоон гарын үсгийн мэдээллийг шинэчилж, сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн бөгөөд орон нутгийн оператор ажилтнуудаар дамжуулан 210 гаруй төрийн үйлчилгээг цахимаар үзүүлж, нийт ХУР, ДАН системээр иргэдэд 61 байгууллагын 660 төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлж байна.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Төсвийн орлого, татвар төлөлт**

2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар улсын төсвийн орлогод өссөн дүнгээр 1,169,953,660.3 төгрөг төвлөрүүлэхээс 1,178,851,577.8 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 100.8 хувь, аймгийн төсвийн орлогод өссөн дүнгээр 930,633,800.0 төгрөг төвлөрүүлэхээс 1,089,903,879.3 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 117.1 хувь, сумын төсвийн орлогод өссөн дүнгээр 5582043.2 төгрөг

төвлөрүүлэхээс 4508770.7 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 80.8 хувийн тус тус биелэлттэй байна

Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 2022 оны 4 дүгээр сарын гүйцэтгэлээр, торгуулийн орлого 114.4 хувиар буюу 40.5 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөр 164.4 хувиар буюу 43.4 сая төгрөгөөр, ус рашааны нөөц ашигласны төлбөр 125.5 хувиар буюу 1.3 сая төгрөгөөр тус тус давж, цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 97.1 хувиар буюу 63.6 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлогын татвар 68.6 хувиар буюу 36.7 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн татвар 40.0 хувиар буюу 151.9 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 68.1 хувиар буюу 29.9 сая төгрөгөөр, газрын төлбөр 38.2 хувиар буюу 43.5 сая төгрөгөөр тус тус тасарсан үзүүлэлттэй байна.

### **Хөрөнгө оруулалт**

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 87922.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 60 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан бөгөөд 2022 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 116033.6 сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирсэн. Төсвийн тодотголоор 700.0 сая.төг-ийн 2 төсөл арга хэмжээ хасагдсан. 400.0 сая.төг-ийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээний тендерийг 2 удаа зарласан боловч шаардлага хангасан тендер ирээгүй, тендер хүчингүй болсон. 39459.3 сая.төг-ийн 1 төсөл арга хэмжээний тендер гомдол гарч Сангийн яаманд хянагдсан бөгөөд тендерийг дахин зарласан. Үлдэх 75474.3 сая.төг-ийн төсөвт өртөг бүхий 23 төсөл арга хэмжээний гэрээг байгуулсан байна.

Байгаль орчин, аялал жуучлалын яамнаас 200.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирсэн. Тендерийг зарласан боловч шаардлага хангасан нэг ч тендер ирээгүй тул тендерийг дахин зарласан.

### **Санхүүгийн хяналт**

Боловсролын салбарын бүтэц орон тоо, цалингийн сангийн гүйцэтгэлд дотоод аудит, ус суваг ашиглалтын “Ар Ус Ундарга” ХХК-ийн 2020-оос 2022 оны эхний 3 сарын байдлаархи санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт тус тус хийгдэж, дүнг аймгийн Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэсэн. Мөн Ихтамир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тамгын газар, төсөвт албан байгууллагууд, сангуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.

Аудит, хяналт шалгалтаар 820.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 27.2 сая төгрөгийн нөхөн төлбөрийг улсын байцаагчийн актаар тогтоож, “Ар Ус Ундарга” ХХК-ийн үйл ажиллагаатай холбоотой 343.7 сая төгрөгийн асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлж, 450.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг чиглэл өглөө

### **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд Хууль, хяналт**

Аймгийн хэмжээнд 2022 оны 5 дугаар сард гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлага нийт 11 удаа гарсанаас: Объектын гал түймэр 6, иргэний хүсэлт 3, малын гоц халдварт өвчин 1, хүний гоц халдварт /ковид-19/ өвчин 1 тус тус гарч аюулт үзэгдэл ослын улмаас 3 гэр, портер автомашин 1, мотоцикл 1 тус тус шатаж нийт 127 сая төгрөгийн хохирол учирсан байна.

Дээрх гамшиг ослын дуудлаганд онцгой байдлын газрын алба хаагч болон мэргэжлийн ангийн 36 алба хаагч, 7 техник хэрэгсэлтэй ажиллаж 11 иргэний амь нас, 107 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн хүрээнд гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтаар гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийн дагуу Архангай аймгийн Онцгой байдлын газрын нийт бие бүрэлдэхүүн хамрагдаж Эрдэнэбулган сумын гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдлыг

хангуулах чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулан ажиллалаа.

Төлөвлөгөөт хяналт шалгалтаар 2268 айл өрхийг хамруулан нийт 1838 зөрчил дутагдлыг илрүүлж, газар дээр нь 578 зөрчлийг арилгуулж бусад зөрчлийг арилгуулахаар заавар зөвлөмж өгч гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 8, мэдэгдэл 9-ийг тус тус бичиж иргэнд хүргүүлж хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

2022 оны 5 дугаар сард Хангай суманд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Өндөр-Улаан, Батцэнгэл, Хотонт суманд гамшгаас хамгалах команд штабын сургууль зохион байгуулсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хаалт, Засаг даргын захирамжаар аймгийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт тус тус оролцож Гал түймэр унтраах, аврах 51-р анги, Эрэн хайх аврах салбарын алба хаагчид үзүүлэх сургалт үзүүлсэн ба тус нээлттэй хаалганы өдөрлөгт нийт 1500 гаруй иргэдэд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээлэл өгч 800 ширхэг санамж гарын авлагыг боршур тараан иргэдэд Онцгой байдлын албыг сурталчлан ажилласан.

“Зөвийг хэвшүүлье” уриан доор зохион байгуулж байгаа “Сурагчийн аюулгүй байдалд эцэг, эх асран хамгаалагчийн үүрэг оролцоо” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Нэгдсэн эмнэлэг УЗХ хамтран осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулан ажилласан. Аймгийн хүүхдийн төлөө төвд бага насны хүүхдийг гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд аюулгүй оролцуулах, анхны тусламж хэрхэн үзүүлэх зэрэг сэдвээр Эрдэнэбулган сумын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, эцэг эх асран хамгаалагчийн төлөөлөлд 2 үе шаттайгаар мэдээлэл хийсэн.

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай албан даалгавруудын хэрэгжилтийг хангаж Хангай, Өндөр-Улаан сумдын онцгой комисс, мэргэжлийн анги, оюутан сурагчдад ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт дадлага зохион байгуулж, санамж боршур тарааж бэлтгэл бэлэн байдлыг шалгаж урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн ажиллаа.

Тус сард нийт ангиллын сургалтын хүрээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль 1 удаа 250 хүнд, команд штабын сургууль 1 удаа 250 хүнд, удирдах ажилтны сургалт 9 удаа 41 хүнд, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн сургалтыг 6 удаа 134 хүнд, ажилтан албан хаагчдын сургалтыг 9 удаа 309 хүнд, оюутан сурагчдын сургалтыг 3 удаа 301 сурагчдад, сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн сургалтыг 2 удаа 158 хүүхдэд, сайн дурын бүлгийн сургалтыг 1 удаа 18 хүнд тус тус зохион байгуулж аюулт үзэгдэл техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх, аврах, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чиглэлээр нийт 24 цагийн танхимын сургалт, дадлага 68 цагийг 924 хүнд зохион байгууллаа.

2022 оны 5 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 228 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 60, хулгайлах гэмт хэрэг 81, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 32, малын хулгайн гэмт хэрэг 43, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 9, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 32, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 13, гэмт хэргийн улмаас нас барсан иргэн 7, гэмт хэргийн илрүүлэлт 54.4 хувьтай байна.

Нийт 10619 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 10093 иргэнд 428.6 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 687.7 сая төгрөг, нөхөн төлүүлэлт 54.8 хувьтай байна.

### **Улсын бүртгэлийн үйлчилгээ**

2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар дараах бүртгэлийн хийж гүйцэтгэсэн байна.

#### **Иргэний бүртгэл:**

- Төрсний бүртгэл – 139

- Овог нэр өөрчлөлт - 6
- Эцэг тогтоолт - 4
- Гэрлэсний бүртгэл - 28
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл - 8
- Үрчилсний бүртгэл - 2
- Нас барсны бүртгэл - 53
- Шинээр иргэний үнэмлэх олгосон - 140
- Дахин олгосон – 11
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 216

#### **Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл:**

- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 30
- Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 25
- Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 1
- Худалдах худалдан авах гэрээ – 99
- Бэлэглэлийн гэрээ – 23
- Барьцааны эрхийн бүртгэл – 289
- Өв залгамжлал – 11
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 14
- Лавлагаа – 24
- Бусад эрхийн бүртгэл – 14

Хууль хяналтын байгууллагад нийт 36 лавлагааг гарган хүргүүлсэн. Дээрхи бүртгэлүүдийг хийж үйлчилгээний хөлс 5487942 төгрөг, тэмдэгтийн хураамжид 278103 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 17905936 төгрөгийг тус тус улсыг төсөвт төвлөрүүлсэн байна.

#### **Хуулийн этгээдийн улсын бүртгэл:**

- Шинээр бүртгүүлсэн – 12
- Өөрчлөлт – 62
- Тамганы хяналтын дугаар олгосон – 14

Шүүхийн шинжилгээний алба 2022 оны 5 дугаар сард криминалистикийн шинжилгээ 5, шүүх эмнэлгийн шинжилгээ 47, тусгай шинжилгээ 38-г хийсэн байна.

2022 оны Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2475502.6 төгрөгийн мөнгөн дүн бүхий 365 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 39.7, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 21.8 байна.

#### **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсрол**

2021-2022 оны хичээлийн жилд 12 дугаар төгсөж их дээд сургуульд элсэх сурагчид Монгол хэл, бичгийн шалгалтыг заавал өгөх бөгөөд шалгалтад орохоор 1043 хүүхэд бүртгүүлснээс 936 хүүхэд шалгалтад орсон. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шалгалтад ороогүй болон босго оноо даваагүй 138 сурагчид 5-р сарын 7-нд шалгалтад дахин хамрагдлаа. Элсэлтийн ерөнхий шалгалтын 2022 оны бүртгэл 2022 оны 02 дугаар сарын 15-наас эхэлсэн бөгөөд бүртгэл 2022 оны 04 дүгээр сарын 15-ны 17 цагт дууссан. Элсэлтийн ерөнхий шалгалтыг өгөхөөр 991 шалгуулагч бүртгүүлсэн. Үүний 856 нь энэ оны төгсөгч, 126 нь өмнөх оны төгсөгчид байна. Эдгээр шалгуулагчдыг хичээл сонголт тус бүрээр авч үзвэл: 1. Математик-518 2. Нийгэм судлал-456 3. Англи хэл-389 4. Хими-231 5. Биологи-231 6. Физик-194 7. Монгол хэл-227 8. Газарзүй-18 9. Монгол улсын түүх-17 10. Орос хэл-3 12-р ангийн сурагчдын элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл ажлыг хангах хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны газраас сорилд 2 зохион байгууллаа. Тус сорилд 12-р ангийн сурагчид 10 хичээлээр давхардсан тоогоор 2174 удаагийн шалгалтад орсон байна.

"Good School" сургалтын байгууллагатай хамтран 2021-2022 оны хичээлийн жилийн 12-р ангийн сурагчдад ЭЕШ-ын хичээлүүдээр сургалтын үйл ажиллагаа явуулж, ЭЕШ-д бэлдэж байна. Уг сургалтад 876 сурагч 1751 хичээлд хамрагдаж дууслаа. Сургалтын төлбөрийн 50 хувийг аймгийн Засаг даргын зүгээс шийдвэрлэн дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан.

"Төсвийн шинэчлэл-2022" уулзалт Архангай аймагт үргэлжилж БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг 5 дугаар сарын 28-ны өдөр багш, удирдлагуудтай уулзаж, төсвийн шинэчлэлийн бодлого, хэрэгжилтийн талаар мэдээлэл өглөө. Уулзалтад аймгийн 300 гаруй багш, удирдлагууд оролсон.

### **Соёл урлаг**

Архангай аймгийн Өлзийт сумын Харганын хөндийд Орхон -Тамир, Хануй-Хүнүйн дурсгалыг түшиглэн байгуулах Төв азийн түүх соёлын голомт соёл аялал жуулчлалын цогцолборын мэдээллийн төвийн барилга баригдаж байна. Барилгын ажлын гүйцэтгэл

5 дугаар 18-ны өдөр, Олон улсын Музейн өдрийг тохиолдуулан аймгийн Засаг дарга М.Батжаргал аймгийн Музейгээр зочилж, үйл ажиллагаатай биечлэн танилцсан байна.

Архангай аймгийн Музей нь "Соёл гэгээрлийн өдрүүд", Олон улсын музейн өдрийн хүрээнд сурагчдын дунд "Соёлын биет бус өвөө хайрлан хамгаалцгаая" өв уламжлалын сэдэвт тэмцээн, Соёлын биет бус өв өвлөн уламжлагч Х.Батбаяр, АВ телевизтэй хамтран "Түүхийн жимээр" танин мэдэхүйн аяллын нэвтрүүлэг, сумдын цэцэрлэгүүдийн дунд бяцхан аялагч зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.

### **Эрүүл мэнд**

2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал:

Батлагдсан тохиолдол:

нийт батлагдсан тохиолдол /2021-2022 он/- 17195

үүнээс: 2022 онд – 4332

сүүлийн 7 хоногт батлагдсан тохиолдол – 14

Нас баралт:

нийт нас баралт – 42

үүнээс: 2021 онд – 39

2022 онд - 3

Түргэвчилсэн шинжилгээ:

нийт хийсэн түргэвчилсэн шинжилгээ /2021-2022 он/ - 51136

үүнээс 2022 онд: - 7979

сүүлийн 7 хоногт хийсэн шинжилгээ – 46

үүнээс эерэг – 4

ПСР шинжилгээ:

нийт хийсэн пср шинжилгээ /2021-2022 он/ - 87211

үүнээс 2022 онд - 9637

сүүлийн 7 хоногт хийсэн шинжилгээ – 162

үүнээс эерэг – 10

Вакцинжуулалт:

1-р тунд 60777 хүн буюу 86,2 % /12-оос дээш нас/

2-р тунд 57562 хүн буюу 81,6 % /12-оос дээш нас/

3-р тунд 27165 хүн буюу 44,5 % /18-аас дээш нас/

4-р тунд 2347 хүн буюу 3,8 % /18-аас дээш нас/

"Эрүүл мэндийн хөгжлийн зуун" нийгэмлэг "we care" төслийн хүрээнд Архангай аймагт 6 настай хүүхдийн зүрхний эрт илрүүлэг хөтөлбөрийг 2022 оны 4 сард хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 6 настай хүүхдүүдэд зүрхний гажигийг эрт илрүүлэх үзлэг,

оношилгоо хийх арга зүйн сургалтыг бүх сум, өрхийн ЭМТ-үүдийн хүүхдийн эмч нарт зохион байгуулан, 6 настай хүүхдүүдэд үзлэг хийж, зөвлөгөө өгсөн.

Зүрхний эрт илрүүлгийн анхан шатны үзлэгт 1474 хүүхэд хамрагдаж үүнээс 200 гаруй хүүхэд зүрхний цахилгаан бичлэгээр өөрчлөлттэй гарсан бөгөөд эдгээр хүүхдүүдэд УГТЭ-ийн зүрхний нарийн мэргэжлийн эмч нар ирж онош тодруулах үзлэг хийж, зөвлөгөө өгсөн.

Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог аймгийн хэмжээнд 5 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 2000 гаруй 0-17 насны хүүхдийг, Нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийг дэмжих төв 500 орчим 18-аас дээш насны иргэдийг хамруулаад байна.

### **Биеийн тамир, спорт**

Монгол Улсын Ерөнхий сайдын санаачлагаар, Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулж буй “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аян орон даяар 2022 оны 02 дугаар 29-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулагдана. Архангай аймагт 32 дахь өдрөө үргэлжилж байна. Аймгийн цэцэрлэг, сургууль, албан байгууллага, аж ахуйн нэгжийн нийт 35 байгууллага идэвхтэй хамрагдаад байна. БТСГ-ын заал, фитнес танхим, 19 сумын сургуулийн зааланд албан байгууллага, аж ахуйн нэгжийн албан хаагчид, сургууль цэцэрлэгийн ажилтан, ЭБ сумын багийн иргэд өглөөний дасгал хөдөлгөөнд хамрагдан, давхардсан тоогоор 4000 хүн хамрагдаад байна.

### **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал**

2022 оны 5 дугаар сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 1258 иргэн бүртгэлтэй байгаагаас 608 эмэгтэй. Шинэ ажлын байр 99, үүнээс байнгын ажлын байр 99 байна.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд**

#### **Мал аж ахуй**

Нийт 19 суманд 67 ажлын хэсэгт 435 хүн ажиллаж **512500** малыг /үхэр, гахай/ вакцинд хамруулахаас **591734** мал хамруулж, вакцинд хамрагдалт **115.4** хувьтай, үлдэгдэл вакцин 0 тун байна.

Сумдын нөөц бүрдүүлэлт өвс, ногоон тэжээл 1855.2 тн, тэжээл 367.2 тн байснаас одоогоор сумдын нөөцөд 1113 тн өвс, ногоон тэжээл, 330 тн тэжээл байна. Аймгийн аюулгүй нөөцөд 100 тн өвс, 341.6 тн ногоон тэжээл, 55.8 тн гар тэжээл байна. Аймгийн хэмжээнд нийт 2.4 сая толгой хээлтэгч мал тоологдсоноос төллөвөл зохих 2.1 сая толгой хээлтэгч малын 79.6 хувь буюу 1.808.5 мянган толгой хээлтэгч мал төллөж 1.752.6 мянган толгой төл мал 97 хувьтай бойжиж байна. Үүнээс төллөсөн хээлтэгч ингэ 211 буюу 7.3 %, гүү 37461 буюу 33.2 %, үнээ 117132 буюу 51.2 %, эм хонь 1123919 буюу 94.5 % эм ямаа 529787 буюу 91.2 хувь нь, нийт бог малын хээлтэгчийн 93.5 хувь, бод малын хээлтэгчийн 40.0 хувь нь төллөсөн байна.

Энэ нь 2021 мөн үеийн төлийн хорогдол нийт гарсан төлийн 5.7 хувь нь хорогдож, 95 хувьтай бойжиж байсан бол энэ оны өнөөдрийн байдлаар гарсан төлийн 3 хувь нь хорогдсон нь өмнөх оны төлийн хорогдлоос 2.7 хувиар бага байна. Аймгийн хэмжээнд 5.5 сая толгой мал тоологдсоноос нийт мал сүргийн 0.4 хувь буюу 22677 мянган толгой мал хорогдсон.

### **Газар тариалан**

Архангай аймаг 2022 онд 8265 га-д үр тариа, үүнээс 7965 га-д улаанбуудай, 4100 га-д малын тэжээл, 600 га-д тосны ургамал, 275 га-д төмс, 166 га-д хүнсний ногоо, 80 га-д жимс жимсгэнэ, нийтдээ 13486 га-д тариалалт хийж 7600 га-д уринш боловсруулахаар бэлтгэл ажлыг ханган ажилласан.

Тариалалт улаанбуудай 6453 га тариалж 80%, төмс 120 га, хүнсний ногоо 70 га, жимс, жимсгэнэ 80 га тариалж, нийт тариалалт 50 хувьтай явагдаж байна.

Үр тарианы үйлдвэрлэлийг 7965 га уриншинд, 4283 га гуурсанд, нийт 12248 га талбайд эрхлэхэд 2082 тн үр шаардлагатайгаас 1144 тн үрийг нөөцөлж, 938 тн үр, 122,48 тн шатахуун, 1048 тн бордоо, 1921 литр ургамал хамгааллын бодисын захиалгыг Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албанд хүргүүлээд байна.

2022 онд газар тариалангийн үйлдвэрлэл аймгийн хэмжээнд төмс 275 га, хүнсний ногоо 166 га, жимс жимсгэнэ 80 га, малын тэжээл 4100 га, тосны ургамал 600 га талбайд тариалахаар төлөвлөөд байна.

Үр тарианы үйлдвэрлэлийг 7965 га уриншинд, 4283 га гуурсанд, нийт 12248 га талбайд үр тарианы үйлдвэрлэл эрхлэхэд 2082 тн үр шаардлагатайгаас 1144 тн нөөцөлж, 938 тн үр, 122,48 тн шатахуун, 1048 тн бордоо, 1921 литр ургамал хамгааллын бодисын захиалгыг хүргүүлсэн.

### **Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд Байгаль орчин**

Архангай аймаг нь Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2030 оныг хүртэлх хугацаанд 20 сая мод тарьж ургуулах төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2021 оны А/713 дугаар захирамжаар байгуулан аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

“Аймгийн хэмжээнд мод тарих ажлыг зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2022 оны А/280 дугаар захирамжаар ажлын байгуулагдаж, мод тарих аяныг угтаж “Тарьц суулгац-2022” үзэсгэлэн худалдааг 2022 оны 5 дугаар сарын 05,06-ны өдрүүдэд аймгийн төвд зохион байгуулж, суулгац материалын нөөцийг бүрдүүлэхэд анхаарч ажиллалаа.

Хаврын мод тарих ажлын хүрээнд 19 сумын хэмжээнд 34945 ширхэг мод, бут сөөгийг тарьж усалгаа, арчилгааны ажлыг гүйцэтгэж байна. Энэ жилийн мод тарих ажлаар төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор сумдын төвийн хашаа, хамгаалалттай сад, цэцэрлэгт хүрээлэнг засаж сэлбэж сайжруулан мод тарих чиглэлийг Засаг дарга нар өгч хамтран ажиллаж байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, элсний нүүлтийг зогсоох, иргэдийн ажиллаж амьдарч буй орчныг ногоон байгууламжтай болгох зорилгоор нэг иргэн нэг мод уриалгыг өрнүүлж иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжил аргагүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

Эрдэнэбулган сумын хэмжээнд хаврын мод тарих өдрийг зохион байгуулах чиглэлээр сумын Засаг даргын 2022 оны А/79 дүгээр захирамжаар Булган уулын хамгаалалттай талбай, аж ахуйн нэгж, албан газруудын эзэмшлийн талбайд тарихыг үүрэг болгож аж ахуйн нэгж иргэд нийт 4264 ширхэг мод, бут сөөгийг тарьж усалгаа, арчилгаа хамгаалалтын ажлыг гүйцэтгэж байна.

5 дугаар сарын 22-ны өдөр буюу Биологийн олон янз байдлыг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг төрийн бус байгууллагаас Булган сумын байгаль хамгаалагч иргэд болон аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төлөөлөлтэй хамтран уулзалт зохион байгуулж, энэ үеэр тус байгууллагаас Булган суманд хэрэгжүүлж буй “Монголын экологийн цагдаа дэлхийн стандартыг нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлэх нь” төслийн хүрээнд “Идэвхтэн байгаль хамгаалагч” болсон Булган сумын 18 иргэнд хувцас, үнэмлэх, 7 нөхөрлөл болон байгаль хамгаалах чиглэлийн байгууллагуудад хяналт шалгалтын тоног төхөөрөмжийг тус тус гардуулсан байна.

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй мэргэжлийн 8 нэгж, байгууллагад 93.0 мянган тарьц суулгацын нөөц байна. Сумдад тарьц суулгацын нөөц тодорхой хэмжээгээр байгаа. Мөн Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүд 430.0 мянган тарьц суулгацыг манай аймагт худалдах сонирхлоо илэрхийлсэн байгаа.

Эрдэнэбулган сумын нийтийн эзэмшлийн талбайд ургаж буй мод, сөөгний нарийвчилсан судалгааг гаргаж 34 цэцэрлэгт хүрээлэнд шинэс, улиас, гацуур, нарс, хайлаас, бургас, шархуйс, агч, гүйлс, хуш, голт бор зэрэг нийт 11 нэр төрлийн 26414 мод, сөөг ургаж байна. Насжилтын хувьд хамгийн бага нь 5 настай, дээд тал нь 5-85 жилийн настай мод 48 га талбайд байна



## **Барилга, дэд бүтэц, газар**

Архангай аймагт 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 171 тэрбум 866.2 сая төгрөгийн өртөг бүхий 69 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 5 дугаар сард орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа дараах 8 барилгын барилга угсралтын ажлын явцад захиалагчийн хяналтыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Хашаат сумын сургуулийн өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэл - 95%

Хайрхан сумын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл - 60%

Жаргалант сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл - 80%

Чулуут сумын 240 хүний суудалтай соёлын төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл - 95 хувь

Чулуут сумын 320 хүний суудалтай сургуулийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл - 90%

Эрдэнэбулган сумын 2 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэл - 25%

Ихтамир сумын ЗДТГ-ын их засварын ажлын гүйцэтгэл - 90%

Ихтамир сумын 10 ортой хүн эмнэлгийн барилгын ажлын гүйцэтгэл - 95%

Аймгийн Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн “Хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй барилгын компаниудад албан даалгаврыг хүргүүлж барилгын талбайн хашаа, хайс хамгаалалтыг сайжруулах, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, санамж, дохио байрлуулах ажлыг 5 дугаар сарын 09-ний дотор хамтран зохион байгуулсан.

“Марч Технологи” ХХК нь “Сувд смарт” хотхоны барилгын ажлыг 2021 оноос гүйцэтгэж эхэлсэн бөгөөд энэхүү хотхон нь Архангай аймагт баригдаж буй хамгийн анхны хотхоны зохион байгуулалттай, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, үйлчилгээний төв зэргийг цогцоор нь төлөвлөсөн, ухаалаг шийдэл бүхий 168 айлын орон сууц юм.

## **Хүнс**

Дотоодын үйлдвэрлэлээр мах, махан бүтээгдэхүүн 4.1 мян.тн бэлтгэж 100%, сүү, сүүн бүтээгдэхүүн 0.3 мян.тн бэлтгэж 12.5%, гурил 0.03 мян.тн бэлтгэж 4%, гурилан бүтээгдэхүүн 0.4 мян.тн бэлтгэж 33%, өндөг 0.012 бэлтгэж 8.6 хувиар аймгийн хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээг хангасан байна. Зориулалтын агуулахад 6 иргэн 230 тн мах нөөцөлсөн байна.

## **Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ**

Худалдаа, үйлдвэр үйлчилгээний “ГОСТ трейд” ХХК аймаг орон нутгийн хөгжилд өнгө үзэмж нэмсэн, улсын жишигт нийцсэн “Хангайн төгөл” эвент холл ресторан, UNI кофе шофыг нээж, үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

“Хөдөө аж ахуйг дэмжих дэмжих зээл”-ийн 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар Хаан банканд 2 иргэн, аж ахуйн нэгжид 90,0 сая төгрөгийн зээл олгож, Төрийн банк, Хас банк, Голомт банк 18 иргэн, аж ахуйн нэгжийн зээл судлагдаж байна.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хүрээнд “Хаан” банк, “Төрийн” банкаар дамжуулан Иргэдэд зориулсан хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн зээл жилийн 10,8 хувийн хүүтэй, Бизнес эрхлэгчдэд зориулан хөрөнгө оруулалтын зээл жилийн 12 хувийн хүүтэй зээлийг олгож байна. Энэхүү зээлийн хүрээнд аймгийн хэмжээнд өнөөдрийн байдлаар 11 аж ахуйн нэгжид 752,5 сая төгрөг, 66 иргэнд 752,4 сая төгрөг нийт 1 тэрбум 504,9 сая төгрөгийн зээл олгоод байна. Үүнээс 27 зээлдэгч 326,3 сая төгрөгийн төслийн батлан даалтад хамрагдсан байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----